

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРИМ ЗААЛТТАЙ  
ХОЛБООТОЙ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА**  
(Харьцуулсан судалгаа)

*Ц.Болормаа, Г.Билгээ, Ч.Онончимэг,  
Д.Халиун, Ц.Элбэгзаяа*

## **ОРШИЛ**

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд дараах 3 гол асуудлаар гадаад орны эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийсэн болно. Үүнд:

1. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан Үндэсний геологийн албатай дүйцэх чиг үүрэг, эрх зүйн статус бүхий алба бусад оронд бий эсэх, тэдгээрийн чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт;
2. Төслийн 8 дугаар зүйлд заасан Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.26-д заасан “мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч” бусад улс оронд байдаг эсэх, ямар болзол шалгуурыг хангасан байдаг, хаанаас эрх олгодог, чиг үүрэг, эрх зүйн статус;
3. Төслийн 5 дугаар зүйлд заасан Ашигт малтмалын тухай хуулийн 48.12 дахь заалтад заасан “...техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, тэдгээрт хийх хөндлөнгийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг мэргэшсэн мэргэжилтэн, эрх бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ” гэсэн заалттай холбогдуулан ТЭЗҮ болон тайланг хэн хийж гүйцэтгэдэг талаарх бусад орны туршлага гэсэн үндсэн 3 чиглэлээр тус судалгааг гүйцэтгэв.

## **Судалгааны товч**

Хуулийн төсөлд заасан “Үндэсний геологийн алба”-ны эрх зүйн статус, үндсэн чиг үүргийг судлахдаа АНУ, Канад, Унгар, Узбекистаны холбогдох байгууллага, түүний эрх зүйн үндсийг тогтоосон хууль, хуульчилсан актын хүрээнд харьцуулан судалсан.

Судалгаанд хуулийн төсөлд заасан “мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч” гэх субъектын олон улсын туршлагыг судлахдаа тухайлсан нэг орныг судлахаар зориогүй бөгөөд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүчин төгөлдөр үйлчилж буй стандартыг гол судлагдахуун болгосон бөгөөд тус стандартыг хичнээн улс, хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх туршлагыг судалсныг судалгааны 2 дугаар хэсгээс үзнэ үү.

## **Нэг. ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАТАЙ ДҮЙЦЭХ БУСАД ОРНЫ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ЭРХ ЗҮЙН СТАТУС, ЧИГ ҮҮРЭГ**

Судалгааны энэ хэсэгт Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1-т заасан “Үндэсний Геологийн алба”-тай чиг үүргийн хувьд дүйцэх бусад орны байгууллага, түүний эрх зүйн үндсийг тогтоосон холбогдох акт болон чиг үүргийн талаарх ерөнхий асуудлыг хамруулсан болно. Үүнд Узбекистан, Унгар, АНУ, Канад зэрэг улсыг түүвэрлэн шаардлагатай мэдээллийг судалсан болно.

## **Нэгдүгээр хэсгийн товч үр дүн**

Судалгааны энэ хэсэгт судлагдсан мэдээллээс үзэхэд АНУ-ын геологийн судалгааны агентлаг хамгийн өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулах ба үүнд дэд бүтэц, аж үйлдвэрлэл болон бусад хөгжлийн төлөвлөлтөд шаардагдах газар нутгийн мэдээлэл, АНУ-ын

Үндэсний аюулгүй байдал болон эрчим хүчний бие даасан байдлыг хангахад шаардагдах ашигт малтмалын тархац, газрын тогтоц, нөөцийн мэдээлэл болон гүний болон хөрсний геологийн бүтцийн судалгаа мэдээлэл, АНУ-ын иргэдийн амь нас, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангахад шаардагдах байгалийн аюул ослын тухай аливаа мэдээлэл, дэлхий ертөнцийн өөрчлөлт, төлөв байдлын тухай гэх мэт өргөн хүрээний судалгаа, шинжилгээний ажил бүхий геологийн мэдээллийн нэгдсэн бааз бүрдүүлэн ажиллаж байна. Тус агентлаг нь Дотоод хэргийн яамны харьяа шинжлэх ухааны агентлагийн статустай бөгөөд нийт 8000 гаруй ажилтан, албан хаагчидтай гэсэн албан ёсны мэдээлэл байна.

Узбекистан улсын хувьд Геологийн алба нь мөн агентлагийн статустай бөгөөд үндсэн чиг үүргийн хувьд ашигт малтмалын салбарт шаардагдах геологийн бүхий л судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэн, геологийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэн ажиллаж байна.

Унгар улсын Уул уурхай, Геологийн алба нь Үндэсний хөгжлийн сайдын харьяанд байх төрийн захиргааны төв байгууллага гэсэн статустайгаар үйл ажиллагаагаа явуулдаг байна. Чиг үүргийн хувьд дан ашигт малтмалын салбарт шаардагдах геологийн судалгаа шинжилгээ хийх бөгөөд ашигт малтмалын нөөцийн удирдлага, концессын гэрээний сайдын шийдвэр бэлтгэж, түүнчлэн энэхүү гэрээний хэрэгжилтийг хянах, уул уурхай, байгалийн хий үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг батлах, уул уурхай, барилга, байгалийн хий хуваарилалт, даралтын тоног төхөөрөмжийн суурилуулах болон тэсэрч дэлбэрэх бодис холбоотой хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх, цуцлах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Канадын геологийн судалгааны алба (КГСА) нь Канадын Эрдэс баялгийн яамны харьяа Геологийн секторын салбар бөгөөд өөрийн орны геологийн хайгуул, эрдэс баялгийн судалгааг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах үүрэгтэй тус улсын хамгийн эртний судалгааны агентлаг байна. Чиг үүргийн хувьд АНУ-ын геологийн агентлагтай төсөөтэй бөгөөд өргөн хүрээний геологийн судалгаа, шинжилгээг гүйцэтгэдэг байна.

#### • Бүгд Найрамдах Узбекистан Улс

Узбекистаны “Геологи, Ашигт малтмалын улсын хороо” нь Узбекистан улсын Ерөнхийлөгчийн 1991 оны 2 дугаар сарын 142 дугаар зарлиг, Узбекистаны Засгийн газрын 1991 оны 5 дугаар сарын 11-ний 125 дугаар тогтоолыг үндэслэн байгуулагдсан байна.

Тус байгууллагын эрх зүйн байдлыг Узбекистаны Засгийн газрын 1996 оны 12 сарын 10-ны өдрийн “Геологи, Ашигт малтмалын улсын хорооны эрх зүйн байдлыг батлах тухай” 435 дугаар тогтоолоор баталсан. Бүтэц, зохион байгуулалтыг “Геологи, Ашигт малтмалын улсын хороо байгуулах тухай” Засгийн газрын тогтоол<sup>45</sup>оор баталсан байна.

#### Үндсэн чиг үүрэг:

Засгийн газрын 1996 оны 12 сарын 10-ны өдрийн 435 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу Геологи, Ашигт малтмалын улсын хороо нь дараах гол зорилготой. Үүнд:

- Геологийн урьдчилсан тооцоо, мэдээлэл авах зорилгоор байгалийн нөөцийн үнэлгээ, газрын гүний геологийн судалгаа болон газрын гүний талаарх бусад мэдээлэл судалгаа хийх;
- Төрийн сангийн геологийн чулуулаг материал болон тусгай хамгаалалттай геологийн объектын менежмент хийх;

<sup>45</sup>Resolution of the Cabinet of Ministers of the Republic of Uzbekistan “On establishment of the State Committee of the Republic of Uzbekistan on Geology and Mineral Resources” №125, dated May 11, 1991.

- Газрын хэвлийн геологийн судалгаа хийх, түүнтэй холбоотой ажлын бүртгэл болон нягтлан бодох бүртгэл хийх, түүнчлэн газрын хэвлийн геологийн мэдээллийн улсын сан ажиллуулах;
- Газрын хэвлийн геологийн судалгаан дээрх төрийн хяналтыг хэрэгжүүлэх үндсэн зорилготой.

Мөн журмын дагуу дараах үндсэн үүрэгтэй байна. Үүнд:

- Узбекистаны нутаг дэвсгэр дэх геологийн судалгааг дүн шинжилгээний түвшинд хийх, улсын хэмжээнд эрдэс баялаг болон түүхий эд, тэдгээрийн тархалтыг хянах, хөгжлийн хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх;
- Геологийн аюултай үйл явцын (хөрсний нуралт, газрын гулсалт, газар улайх гэх мэт) үед авч хэрэгжүүлэх цогц ажлыг бүрэлдүүлэн бий болгох, хөгжүүлэх;
- Ашигт малтмалын хайгуулын ажлын техник, технологи болон инженерчлэлийг сайжруулах түүнчлэн ашигт малтмалын хайгуулын ажлын шинжлэх ухааны таамаглалыг сайжруулах асуудлаар техникийн болон шинжлэх ухааны нэгдсэн бодлого баримтлан, уялдааг хангах;


Мөн тус журамд заасны дагуу дараах үндсэн эрхтэй. Үүнд:

- Газрын хэвлий ашиглагчдын ашигт малтмал ашиглах болон геологийн судалгаа шинжилгээ хийхтэй холбоотой үүргээ биелүүлэхтэй холбогдсон дүрэм, журам, арга зүйн заавар болон бусад норматив акт гаргах;
- Ашигт малтмал ашиглах болон газрын хэвлийн геологийн судалгаатай холбоотой улсын геологийн болон геоэкологийн газрын зураг, атлас болон зураг зүйн бусад материал, шинжлэх ухааны баримт бичиг, заавар, гарын авлага, сонин сэтгүүл бусад ном зохиолыг эрхлэн гаргах.

Тус тогтоолоор Узбекистаны “Геологи, Ашигт малтмалын улсын хороо” нь дараах бүтэцтэй байхаар баталсан байна.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

Зураг 1. “Геологи, Ашигт малтмалын улсын хороо”-ны бүтэц




- **Бүгд Найрамдах Унгар улс**

Уул уурхай, Геологийн алба /MBFH<sup>46/</sup> нь Унгарын Үндэсний хөгжлийн сайдын удирдлага дор ажиллах төрийн захиргааны төв байгууллага юм. 1961 онд тус албаны эрх зүйн орчинг бүрдүүлснээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд тус албаны эрхлэн гүйцэтгэх үйл ажиллагаа, чиг үүрэг, эрх мэдлийг Засгийн газрын 267/2006<sup>47</sup> тогтоолоор тогтоосон.

Уул уурхай, Геологийн алба нь улсын хэмжээнд болон бүс нутгийн буюу дүүргийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд геологи хайгуулын ажлыг хариуцан ажилладаг байгууллага юм.

**Зураг 2. Унгарын уул уурхай, Геологийн албаны бүтэц, зохион байгуулалт**



<sup>46</sup><http://www.mbfh.hu/home/html/index.asp?msid=1&sid=0&HKL=1&Ing=1>

<sup>47</sup>[http://net.jogtar.hu/jr/gen/hjegy\\_doc.cgi?docid=A0600267.KOR&celpara=#xcelparam](http://net.jogtar.hu/jr/gen/hjegy_doc.cgi?docid=A0600267.KOR&celpara=#xcelparam)

ЗГ-ын 261/2006 оны тогтоолоор<sup>48</sup> Унгар улсын мужуудын уул уурхайн хэрэг эрхлэх газруудыг (MBFH) дараах байдлаар тогтоосон.

- Budapest -ийн Уул уурхайн Хэрэг эрхлэх газар
- Miskolc - ийн Уул уурхайн Хэрэг эрхлэх газар
- Pecs - ийн Уул уурхайн Хэрэг эрхлэх газар
- Szolnok - ийн Уул уурхайн Хэрэг эрхлэх газар
- Veszpremi - ийн Уул уурхайн Хэрэг эрхлэх газар

Уул уурхай, Геологийн албаны үндсэн чиг үүрэг:

- Ашигт малтмалын нөөцийн удирдлага, концессын гэрээний сайдын шийдвэр бэлтгэж, түүнчлэн энэхүү гэрээний хэрэгжилтийг хянах;
- Уул уурхайн хуулийн 34<sup>49</sup>дэх хэсэгт дурдсан уул уурхай, байгалийн хий үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг батлах;
- 1993 оны Уул уурхайн хуулийн XLVIII, Засгийн газрын 203/1998 тогтоолын дагуу уул уурхай, барилга, байгалийн хий хуваарилалт, даралтын тоног төхөөрөмжийн суурилуулах болон тэсэрч дэлбэрэх бодис холбоотой хуульд заасан тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэх, цуцлах;
- Техникийн төлөвлөгөөг батлуулах, эрдэм шинжилгээний тэтгэлэг зарлах, сонгон шалгаруулах, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг гүйцэтгэх;

Уул уурхайн Хэрэг эрхлэх газрын бүрэн эрх:

1. Уул уурхайн хуулийн 41.8-д заасан уурхайн хяналтын төлбөр хураалтын явц, дансанд байршуулах явцад хяналт тавих, төлбөр тооцоонд хяналт тавих, цуглуулах;
2. Хөдөлмөрийн хяналтын болон ажлын аюулгүй ажиллагааны 1993 оны хуулийн ХСIII 83 (Б1996 хууль, дугаар LXXV-ийн 8-р хэсэг) С-д заасан үүргийг биелүүлэх;
3. Уул уурхайн хяналтын байгууллагуудад тавигдах аюулгүй ажиллагааны дүрэм журмыг батлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;
4. Ашигт малтмалын нөөцийн удирдлага, концессын гэрээг байгуулах, энэ талаар тодорхой шийдвэр гаргах;
5. Уул уурхайн хуулийн 34-р зүйлийн (2) дахь хэсэгт заасан уул уурхай, байгалийн хий үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны дүрэм журам, норм нормативыг батлах;
6. Уул уурхайн хуулийн 26-р зүйлийн (5) заасны дагуу өргөдлийн хугацааг сунгах, үнэлгээ хийх;
7. Унгарын Геологи, геофизикийн болон уул уурхай, ашигт малтмалын нөөцийн улсын бүртгэлийн мэдээллийн сан, Геологи, Уул уурхайн мэдээллийн системийн менежментыг хариуцан гүйцэтгэх;
8. Үндэсний эрдэс, түүхий эдийн бүртгэл хөтөлж, геотермик эрчим хүчний нөөцийг тодорхойлох, судалгаа хийх, гэрчилгээ олгох;
9. Геологийн мэргэжлийн лиценз олгох, геологийн мэргэжилтнүүдийн бүртгэл хөтлөх зэрэг болно.

## • АНУ

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд байх “Үндэсний Геологийн Алба”-тай чиг үүргийн хувьд дүйцэх АНУ-ын төрийн байгууллага буюу Засгийн газрын агентлаг нь “United States Geological Survey” буюу “АНУ-ын Геологийн Судалгааны Агентлаг”<sup>50</sup> юм.

“АНУ-ын Геологийн Судалгааны Агентлаг” нь эрх зүйн статусын хувьд АНУ-ын Дотоод

<sup>48</sup><http://www.mbfh.hu/home/html/index.asp?msid=1&sid=0&hkl=558&lng=1>

<sup>50</sup>United States Geological Survey

хэргийн яамны харьяа агентлаг бөгөөд агентлагийн даргыг АНУ-ын Ерөнхийлөгч Сенатын танхимтай зөвшилцөн томилно.<sup>51</sup>

Мөн хуулийн 31 дүгээр зүйлийн А заалтад зааснаар “АНУ-ын Геологийн Судалгааны Агентлаг” -ийн дарга нь агентлагийн төрийн өмчийн газар түүнтэй холбоотой геологийн бүтцийн судалгаа шинжилгээ, байгалийн баялгийн нөөц, үндэстний эзэмшил газрыг төрөлжүүлэх ажлыг шууд удирдлагаар хангана.

АНУ-ын Геологийн судалгааны агентлагийн захирал болон гишүүд нь газар, түүний ашигт малтмалын баялагтай холбоотой хувийн ашиг сонирхолтой байж болохгүй бөгөөд геологийн судалгаа, шинжилгээний ажлын хувьд аль нэг нам, эвсэл, аж ахуйн нэгжээс хараат бус байна.

Тус агентлагийн эрх зүйн үндсийг АНУ-ын USCode title 43 буюу АНУ-ын Гол Кодын 43 дэх гол хууль болох “Public Land”-ийн 2 дугаар бүлгээр<sup>52</sup>, мөн Нэгдсэн улсын хэмжээнд үйлчлэх Нэгдсэн улсын Кодын холбогдох бусад хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан хуулиар зохицуулна.

“АНУ-ын Геологийн Судалгааны агентлаг” нь байгалийн гамшгаас үүдэлтэй иргэдийн амь нас, эд хөрөнгийн хохирлыг багасгах, ус, биологи, эрчим хүч, эрдэс баялгийн нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх болон ард түмний амьдралын чанарыг сайжруулах, хамгаалахад шаардагдах шинжлэх ухааны бодит мэдлэгээр Үндэстнийг хангах үндсэн зорилготой байна. Үүнээс харахад АНУ-ын геологийн агентлагийн хувьд бусад орны ижил чиг үүрэг бүхий байгууллагуудаас зорилго, чиг үүргийн хувьд илүү өргөн хүрээтэй байгууллага болох нь харагдаж байна.

### **Хуулиар тогтоосон үндсэн чиг үүрэг**

АНУ-ын Геологийн судалгааны агентлагийн тухай хуулийн<sup>53</sup> 31А дүгээр зүйлд заасны дагуу тус байгууллага нь геологийн бүхий л төрлийн тандалт судалгааны анхдагч мэдээллийн бааз бүрдүүлэх, геологийн газрын зураг гаргах бөгөөд үүнд хамааралтай дараах судалгаа, шинжилгээний ажлыг хийнэ. Үүнд:

1. Ашигт малтмал, эрчим хүч, усны нөөцийн шинжилгээ, хайгуулын ажлыг хийх, хөгжүүлэх,
2. Хорт болон цөмийн хаягдал булшлах газрыг тодорхойлох, илрүүлэх,
3. Хүрээлэн байгаа орчин болон газар нутгийн хамгаалах төлөвлөгөө болон газар ашиглалтын үнэлгээ,
4. Газар хөдлөлтийн аюулыг бууруулах,
5. Галт уулын аюулыг тодорхойлох,
6. Гадаргуу ус хуримтлуулах болон тээвэрлэлтийн шугам, хотын болон нийтийн зориулалтын барилга байгууламж гэх мэт дэд бүтцийг төлөвлөх, байгуулах,
7. Хөрсний нуралт, газрын гулгалт гэх мэт газрын эвдрэлийг бууруулах,
8. Эрэг хавийн газрын усны урсгалд идэгдэх эвдрэлийг багасгах,
9. Осолтой үйлдвэрийн барилга байгууламжийг байрлуулах,
10. Геологийн суурь судалгааны ажлыг гүйцэтгэнэ.

<sup>51</sup>USCode, Title 43, Chapter II, 31-р зүйлийн а заалт. <http://www.law.cornell.edu/uscode/text/43/31>

<sup>52</sup><http://uscode.house.gov/browse/prelim@title43/chapter2&edition=prelim>

<sup>53</sup>USCode, Title 43, Chapter II, 31A <http://www.law.cornell.edu/uscode/text/43/31a>

Мөн хуулийн 31 дүгээр зүйлд зааснаар:

1. Зардал ихтэй байгаль орчны тулгамдсан асуудал, түүнтэй холбоотой маргаан, төсөл эхлэхийн өмнө байгаль орчинд учирч болзошгүй хохирлын цар хүрээг тодорхойлоход шаардагдах геологийн газар зүйн зургийн мэдээллээр холбооны агентлагууд, төрийн болон орон нутгийн засаг захиргаа, хувийн үйлдвэр болон олон нийтийг хангах,
2. АНУ-ын үндэсний аюулгүй байдал, байгал орчны хамгаалалт, болон Үндэсний эрчим хүчний бие даасан байдлыг хангахад шаардагдах геологийн газрын зургаар Муж, Холбоо болон шинжлэх ухааны бүлгийг хангах, тэдгээрийг нэгтгэх,
3. Муж улсуудын геологийн газрын зургийг тэдгээрийн тавин хувийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хийх,
4. Хог хаягдал хаях байгууламж, далан зэрэг байгууламжийн төлөвлөлтийг сайжруулах,
5. Чухал хэрэгцээтэй нь нотлогдсон чулуужсан түлш, ашигт малтмалын нөөцийн хайгуул болон хэрэгцээний геологийн газрын зураг гаргах,
6. Тогтвортой, тэнцвэртэй хөгжлийг хангах шаардлагатай бүх байгалийн баялгийн төрөл, тэр дундаа эрчим хүч, ашигт малтмал, газар, ус, биологийн нөөцийн геологийн зургийн мэдээллийг гаргах,
7. Газрын болон байгалийн баялгийн нөөцийн менежментийн шийдвэр гаргахад шаардагдах геологийн зураг зүйн мэдээллийн сан бий болгох, түүнийг газарзүйн мэдээллийн нэгдсэн систем болон дижитал технологи болгон өргөжүүлэх,
8. Үндсэн чулуулгийн орд болон гадаргуун геологийн зураглалын цогц Үндэсний хөтөлбөрийн дагуу улсын хэмжээнд системтэйгээр геологийн зураглалын мэдээллийн бааз бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй байна.

(b) Энэ хуулийн 31а-аас 31h -д заасан геологийн судалгаа, шинжилгээний зорилго нь АНУ-ын Геологийн судалгааны байгууллагын дотоод бүтцэд байх Үндэсний газар зүйн зураглалын мэдээллийн сангийн боловсруулалтын ажлыг хурдасгахад чиглэсэн бөгөөд энэ нь газар ашиглалтын удирдлага, үнэлгээ, ашиглалт, байгалийн нөөцийн хадгалалт, хамгаалалт, газрын гүний усны удирдлага болон байгаль орчны хамгаалалтын менежментэд ашиглагдана.

Тус байгууллагын бүтцийг ерөнхийд нь захиргаа удирдлагын, мэргэжлийн, бүс нутаг хариуцсан гэж гурав ангилж болохоор байх бөгөөд Геологийн судалгааны мэргэшлийн дараах албадтай байна. Үүнд:

1. Экосистем,
2. Уур амьсгалын болон газар ашиглалтын өөрчлөлт,
3. Байгалийн осол, аюул,
4. Ус,
5. Эрчим хүч, байгалийн баялаг болон Байгаль орчны эрүүл мэнд,
6. Үндсэн шинжлэх ухааны систем гэсэн мэргэжлийн үндсэн албууд байх бөгөөд дотоодын болон олон улсын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулахад нь шаардлагатай дараах нэгж байна. Үүнд:
  - Олон улсын Хөтөлбөрийн алба,
  - Шинжлэх ухааны чанар, цогц байдлын алба,
  - Аж үйлдвэрийн мэдээлэл болон байгалийн нөөцийн мэдээллийн алба гэх мэт нэгжүүд байхаас гадна байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардагдах санхүү, харилцаа холбоо, хүний нөөц, бодлого төлөвлөлт, захиргаа удирдлагын газруудтай байна.

- **Канад**

Канадын геологийн судалгааны алба (КГСА)<sup>54</sup> нь Канадын Эрдэс баялгийн яамны<sup>55</sup> харьяа Геологийн секторын салбар бөгөөд өөрийн орны геологийн хайгуул, эрдэс баялгийн судалгааг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах үүрэгтэй. КГСА нь тус улсын эртний судалгааны агентлаг юм.

КГСА-ны эрх зүйн байдлыг Канадын Газрын судалгааны тухай хуулиар<sup>56</sup> тогтоосон ба Эрдэс баялгийн яамны харьяа агентлаг байхаар заасан байдаг.

Геологийн судалгааг Канадын Эрдэс баялгийн сайд хуульд заасан журмын дагуу удирдах, чиглүүлэх, хяналт тавих үүрэгтэй (хуулийн 3(1)), Ерөнхий шинжээч нь судалгааны ажлуудыг удирдан чиглүүлнэ (хуулийн 3(2), 24(2)).

Канадын геологийн судалгааны алба нь зөвхөн ашигт малтмалтай холбоотой геологийн судалгаа хийхгүй бөгөөд дэд бүтэц, хилийн бүс, аж үйлдвэрлэл болон хөгжлийн тусгай төсөл, хөтөлбөрүүдэд шаардлагатай геологийн бүхий л төрлийн суурь судалгаа, зураглал, газрын төлөвлөлт хийдгээрээ үйл ажиллагааны хувьд илүү өргөн хүрээг хамарна.

Судалгаа гэдэгт дахин шинжлэн судлахаас гадна тусгай шинжилгээ судалгаа хамаарна (хуулийн 2(1)).

Канадын Газрын судалгааны тухай хуулийн 33 дугаар зүйлд зааснаар дахин судалгаа гэдэг нь Канадын газрын нэгдсэн зураглалын алдааг залруулах, газар төлөвлөлтөд ороогүй дурсгалт газруудыг дахин төлөвлөх зорилгоор хийгдэж буй судалгааг ойлгоно.

Тус хуулийн 35 дугаар зүйлд зааснаар Канадын нийт нутаг дэвсгэрийн газрын тусгай судалгаанд дараах судалгаа хамаарна. Үүнд:

- Нэгэнт хийгдсэн судалгаа шинжилгээ, төлөвлөгөөний алдааг тогтоох, тодорхойлох,
- Холбогдох салбарт хэрэгжүүлж буй төлөвлөгөөний алдааг газрын тогтоц, бүс нутгийн шинжээр нь ангилан тодорхойлох,
- Хурдны зам, гудамжийг байршлыг тогтоох,
- Түүх дурсгалын газрын байрлалыг тодорхойлоогүй эсхүл өөр бусад шалтгааны улмаас хилийн шугамын байрлалыг буруу тогтоосныг засварлах,
- Сайд болон Комиссарын үүрэг болгосон бусад судалгаа.

Түүнчлэн хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу Эрдэс баялгийн яамны сайд болон Комиссарын үүрэг болгосноор заасан нутаг дэвсгэрт газрын тусгай судалгааг хийж гүйцэтгэнэ. Эрдэс баялгийн яамны сайдын өгсөн үүрэг даалгаврын дагуу хийгдэж буй газрын тусгай судалгааг тус агентлагийн дарга буюу ерөнхий шинжээч удирдана.

КГСА нь бүтцийн хувьд дараах салбар, нэгжтэй. Үүнд:

- Атлантын болон Канадын баруун бүсийн салбар:
  - Аюултай үзэгдлийн мэдээллийн алба
  - Атлантын КГСА
  - Калгарийн КГСА
  - Номхон далайн КГСА
  - НҮБ-ын Далайн эрх зүйн тухай конвенц (UNCLOS)<sup>57</sup>

<sup>54</sup>Англи: The Geological Survey of Canada (GSC). Франц: Commission Géologique du Canada (CGC).

<sup>55</sup>Англи: The Department of Natural Resource Funding, эсхүл Natural Resources Canada (NRCan). Франц: Ministère des Ressources naturelles.

<sup>56</sup>Canada Lands Surveys Act. R.S.C., 1985, c. L-6.

<sup>57</sup>United Nations Convention on the Law of the Sea (UNCLOS).

- Канадын төв болон хойд бүсийн салбар:
  - Квебекийн КГСА
  - Төв КГСА
  - Хойд Канадын КГСА

### **Хоёр. “МЭРГЭШСЭН МЭРГЭЖИЛТЭН, ШИНЖЭЭЧ” БОЛОН ТЭЗҮ, АШИГЛАЛТЫН ТАЙЛАН БОЛОВСРУУЛАХ ЭРХ БҮХИЙ СУБЪЕКТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, БУСАД УЛС ОРНЫ ТУРШЛАГА**

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 8 дугаар зүйл болон 5 дугаар зүйлд заасан нэмэлт, өөрчлөлтүүдтэй холбогдуулан судалгааны энэ хэсэгт дараах хоёр асуудлыг нэгтгэн авч үзэж, олон улсын туршлагыг харьцуулан судаллаа. Үүнд:

- 1) Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 8 дугаарт заасан Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.26-д заасан “мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч” тухай ойлголт бусад улс оронд байдаг эсэх, ямар болзол шалгуурыг хангасан байдаг, хаанаас эрх олгодог талаар;
- 2) Төслийн 5 дугаарт заасан Ашигт малтмалын тухай хуулийн 48.12 дах хэсэгт заасан “...техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, тэдгээрт хийх хөндлөнгийн дүгнэлт гаргах үйл ажиллагааг мэргэшсэн мэргэжилтэн, эрх бүхий хуулийн этгээд гүйцэтгэнэ” гэсэн заалттай холбогдуулан бусад оронд ТЭЗҮ болон тайланг хэн хийж гүйцэтгэдэг талаарх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн CRIRSCO, UNFC-ын хүрээнд харьцуулсан судалгаа хийв.

Өдгөө ашигт малтмалын нөөцийг ангилах, тайлагнах<sup>58</sup>үндсэн хоёр тогтолцоо олон улсын хэмжээнд байдаг. Энэ нь:<sup>59</sup>

- Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын хувьд хөрөнгө оруулагчдад үнэн зөв, ил тод, бодитой мэдээ, мэдээллээр хангахад түлхүү чиглэсэн CRIRSCO стандарт.
- Төрийн болон төрийн бус байгууллагуудад өөрсдийн уул уурхай, ашигт малтмалын талаар баримтлах бодлого боловсруулах, хөрөнгө оруулалт татах болон хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чиглэсэн UNFC загвар.

### **CRIRSCO-ийн стандарт**

“Ашигт малтмалын нөөцийг тайлагнах олон улсын стандартын хороо” *CRIRSCO (Committee for Mineral Reserves International Reporting Standards)* нь 1994 онд анх Уул уурхай болон металлургийн хүрээлэнгүүдийн зөвлөл (Council of Mining and Metallurgical Institutions – CMMI)-ийн ивээл дор байгуулагдсан ба Австрали, Канад, Чили, Европ, Өмнөд Африк болон АНУ зэрэг улсуудын ашигт малтмалын тайлагнах стандарт болон удирдамж боловсруулах асуудал хариуцсан байгууллагуудын төлөөллийн байгууллага юм.

Дээрх улс орнуудын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй уул уурхайн компаниуд уул уурхайн зах зээлийн 80 хувийг эзэлдэг байна. 2011 онд ОХУ элссэнээр долоон орныг төлөөлж байгаа аж. Дээрх долоон орны араас Перу, Хятад, Филиппин, Индонези, Турк зэрэг улс элсэх бэлтгэлээ хийж байна.

<sup>58</sup>Холбогдох тайлбарыг судалгааны 2 дугаар хэсгийн холбогдох хэсэгт оруулсан болно.

Хэрэгцээ, шаардлага: Олон нийтэд ашигт малтмалын нөөцийн талаар мэдээлэх доод стандартыг тогтоох гол шалтгаан нь олон нийтэд ил тод, нэг загварын, бодитой мэдээлэл хүргэх системийг бий болгосноор хөрөнгө оруулагчдад уул уурхайн салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлж, улмаар улс орны хөрөнгийн зах зээлийн шууд болон шууд бусаар бэхжүүлэх явдал юм. Энэхүү системийн гурван гол зарчим нь: 1/ уул уурхайн төслийн техник болон шинжлэх ухаантай холбоотой мэдээ, мэдээллийг хариуцлагатай болгох “эрх бүхий буюу мэргэшсэн этгээд”-тэй болох. 2/ мэдээ, мэдээллийг техникийн тайланд тусгаж, баталгаажуулах явдлыг “эрх бүхий буюу мэргэшсэн этгээд”-д хариуцуулах. Мөн 3/ ашигт малтмалын ордын нөөц болон ашигт малтмалын баялагтай холбоотой нэр томъёо, ойлголтыг жигдрүүлэх явдал юм. <http://www.casselsbrock.com/files/file/docs/MiningDisclosure.pdf>

<sup>59</sup><http://www.vmine.net/perc/documents/EGM-PAPER-PERC2013.pdf>

Эдгээр улс орнууд нь ашигт малтмалын ордын нөөцийн тооцоолол, эрдсийн баялгийн үнэлгээтэй холбогдох судалгаа буюу ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын үнэн зөв, бодит мэдээллийг бүрдүүлэх журам боловсруулах, хөрөнгө оруулагчдад үнэн зөв мэдээлэл хүргэх, олон улсын хөрөнгийн биржид эрдэс баялгийн боломж болон ашигт малтмалын нөөцийг тайлагнах стандарт боловсруулах ажлыг (Канадын “Бри-Экс” компани 1993, 1995 онуудад Индонезид алтны их хэмжээний нөөц бүхий орд газартай гэж мэдээлж, олон улсын хөрөнгийн биржээс их хэмжээний мөнгө босгож чадсан боловч хуурамч мэдээлэл өгч, залилан хийж байсан нь тогтоогдсоноос хойш<sup>60</sup>) санаачилсан ба үр дүнд нь 1999 онд 1989 оны Австралазийн ЖОРК (Австралийн хүдрийн нөөцийн хороо) JORC (Joint Ore Reserve Committee)-ийн баталсан стандартыг шинэчилж, хайгуулын үр дүн, хүдрийн нөөцийн талаар олон нийтэд мэдээлэх доод стандартыг тогтоож өгсөн байна.

Тус стандарт нь цаашлаад Өмнөд Африк, АНУ, Канад, Англи, Ирланд, Баруун Европ, Чили болон Перу улс орнуудын стандартыг боловсруулах үндэс нь болсон ба дээрх улс орнуудын тайлан бичих загвар, нэр томъёоны тодорхойлолтууд нь ижилхэн, эсвэл агуулгын хувьд зарчмын зөрүүгүй байдаг.

Дээрх улс орны боловсруулсан стандартын үндсэн дээр CRIRSCO загварын тайлагнах журам, стандарт боловсруулах сонирхолтой улс орнуудад зориулан жишиг стандарт боловсруулсан гаргасан байдаг.<sup>61</sup>

CRIRSCO нь олон улсын зөвлөх байгууллагын статустай бөгөөд гагцхүү гишүүн орнууд нь өөрсдөө стандарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, зохицуулах ажлыг гүйцэтгэх юм. CRIRSCO стандартын гол хэрэглэгчид нь:

- Уул уурхайн компаниуд;
- Санхүүгийн байгууллагууд;
- Хөрөнгийн биржүүд;
- Засгийн газрууд;
- Хувьцаа эзэмшигчид байна.

CRIRSCO-ийн гишүүн орнууд<sup>62</sup> нь бие биенийхээ стандартыг хүлээн зөвшөөрдөг ба тухайлбал Канадын NI 43-101 болон Австралийн JORC стандартыг хамтын гэрээний үндсэн дээр харилцан хүлээн зөвшөөрөх ба ийм төрлийн стандарт батлаагүй болон олон улсад хүрээнд зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллагагүй орнуудын хувьд дээрх стандартуудыг *de facto* стандарт гэж үзэж байна.

UIN.MN  
CAN

<sup>60</sup>1989 онд Дэвид Волш гэгч “Бри-Экс” компанийг байгуулж, Албертийн хөрөнгийн биржид хувьцаагаа гаргажээ. 1995 онд Бусан-II гэх төсөл дээр ажиллаж, өрөмдлөгийн ажил хийснээр үр дүн нь эерэг гарсан байна. Үүний дараа Торонтогийн хөрөнгийн биржид бүртгүүлж нэгж хувьцааг 187.5 доллараар гаргажээ. 1996 оны зургадугаар сард “Бри-Экс” компани Бусан-II орд 39.15 сая унци алтны нөөцтэй гэдгээ тайлагнаж, зургаан сарын дараа 70.95 сая унци болтлоо нөөц нь нэмэгджээ. 1996 оны наймдугаар сард Монреалын хөрөнгийн бирж болон NASDAQ-т бүртгүүлжээ. Алтны нөөц нь 70 сая унци болсон гэж мэдэгдсэний дараа “Бри-Экс”-ийг уул уурхайн томоохон компаниуд сонирхож, “Фрипорт-Макморан” компанитай хамтран ажиллах гэрээ байгуулав. Бусан-II ордын нөөц 200 сая унци болон нэмэгдэх боломжтой бөгөөд тэгвэл 95 тэрбум долларын өртөгтэй болох талаар компанийн удирдлага мэдээлжээ. Энэ үед “Бри-Экс”-ийн зах зээлийн үнэлгээ 4 тэрбум долларт хүрч байв. Гэрээ хийснээсээ нэг сарын дараа Бусан-II-т хэд хэдэн өрөмдлөг хийсэн “Фрипорт-Макморан”-ынхан маш бага алтны нөөцтэй болохыг тогтоожээ. Ийнхүү хөрөнгийн зах зээлээс хэдэн арван тэрбум доллар босгоод байсан “Бри-Экс” компани хуурамч мэдээлэл өгч, залилан хийж байсан нь тогтоогджээ. Энэхүү алдарт залилангаас үүдэн Канадын Үнэт Цаасны Удирдах газраас NI 43-101 гэх дүрмийг гаргажээ.” <http://www.mongolianminingjournal.com/content/14861.shtml>

<sup>61</sup>Жишиг стандартын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү: <http://www.criresco.com/template.asp>

<sup>62</sup>Гишүүн орнууд болон CRIRSCO стандартын хэрэглээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-с үзнэ үү.

Хүснэгт 1. CRIRSCO гишүүн орнуудын тайлагнах стандарт

Улс орны нэр	Ашигт малтмалын нөөцийг тайлагнах стандартын нэр
Австрали	The JORC Code /2012/
Канад	NI 43-101; The CIM Definition Standards on Mineral Resources and Reserves /2010/
Өмнөд Африк	The SAMVAL Code /2008/ The SAMREC Code /2007/
Европ	Pan-European Reserves & Resources Reporting Committee Pan-European Standard for Reporting of Exploration Results, Mineral Resources and Reserves /"The PERC Reporting Standard"/ 2013, revision 2
АНУ	The SME Guide for reporting Exploration Results, Mineral Resources and Mineral Reserves /2007/
Чили	Certification Code for Exploration Prospects, Mineral Resources and Ore Reserves /2004/
ОХУ	The NAEN Code for the Public Reporting of Exploration Results, Mineral Resources, Mineral Reserves.

CRIRSCO гишүүн орнуудын стандартад олон нийтэд хүргэх мэдээллийг **мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч** (ихэнх орнуудад “эрх бүхий этгээд” - competent person; Канадад “мэргэшсэн этгээд” - qualified person; Чили улсад “мэргэшсэн эрх бүхий этгээд” - qualified competent person гэх)-ийн зөвлөгөөгөөр гаргана гэж зааснаас гадна тус мэргэжилтэнд тавигдах шаардлагыг тогтоож өгсөн байна.

Жишээ нь дээрх стандартуудад тавигдаж буй нийтлэг шаардлагуудад тус этгээд нь уул уурхай, хайгуулын салбарт **доод тал нь таван жилийн туршлагатай**, хэрэв ашигт малтмалын боломжийн тооцоог хийх буюу тооцоо хийх ажлыг удирдах гэж байгаа бол ашигт малтмалын боломжийг тооцоолох, үнэлэх талаар хангалттай туршлагатай байх, мөн олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн **мэргэжлийн холбооны гишүүн байх** ёстой аж.

**Канадын NI 43-101 стандартад “мэргэшсэн этгээд”-ийг дараах байдлаар тодорхойлсон байна:**

- геологийн шинжлэх ухаан эсхүл инженерийн мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн буюу ашигт малтмалын хайгуул эсхүл уул уурхайн салбарт хамаарах геологи эсхүл инженерийн дээр дурдсантай дүйцэхүйц болзлыг хангасан байх;
- ашигт малтмалын хайгуул, уурхайн ашиглалт, ашигт малтмалын төслийн үнэлгээ, ашигт малтмалын боломжийн тооцооны асуудлаар, өөрийн мэргэжлийн чиглэлээр доод тал нь таван жилийн туршлагатай байх;
- ашигт малтмалын төсөл болон техникийн тайлан бэлтгэх туршлагатай байх;
- мэргэжлийн холбооны гишүүн байх;
- гадаад орны мэргэжлийн холбооны хувьд, тухайн холбооны гишүүн байх;
- өөрийн мэргэжлийн чиглэлээр бие даасан шийдвэр гаргах хэмжээний албан тушаал эрхэлдэг байх;
- хувь хүний тодорхойлолт, мэргэжлийн ур чадвар, дадлага, туршлага болон ёс зүйн хувьд тодорхой шалгуурыг хангасан байх;
- ашигт малтмалын хайгуул, уул уурхайн салбартаа нэр хүндтэй, мэргэшсэн мэргэжилтэн байхаас гадна хоёроос доошгүй мэргэшсэн этгээдээс нэр дэвшихийг нь дэмжсэн санал авсан байх гэж заасан байна.

**Австралийн JORC стандартад “эрх бүхий этгээд”** нь дээр дурдсан нийтлэг шалгуураас гадна Австралийн уул уурхай болон металлургийн хүрээлэн, эсхүл Австралийн геологийн шинжлэх ухааны хүрээлэн, эсхүл “Хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллага”-ын гишүүн эсхүл судлаач /fellow/ байх ёстой гэж заасан байна.

### Мэргэшсэн этгээдийн чиг үүрэг (Канад)

Мэргэшсэн этгээд нь олон нийтэд мэдээлэх үнэлгээ, тайлан, мэдээг хянах үүрэгтэй ба гарсан мэдээллийн үнэн зөв, ил тод байдалд хариуцлага хүлээнэ<sup>63</sup>.

Нэг буюу түүнээс дээш мэргэшсэн этгээд өөрөө эсхүл түүний удирдлага дор **техникийн тайлан** (technical report)<sup>64</sup>-г бэлтгэнэ. Техникийн тайлангийн хэсгийг эсхүл бүхэлд нь бэлтгэсэн эсхүл хянасан мэргэшсэн этгээд нь тайланд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд тэмдэгтэй бол, тэмдэг дарж баталгаажуулна. Мэргэшсэн этгээд нь баталгаажуулсан тайланг **санхүүгийн үйлчилгээг зохицуулах байгууллагад** хүргүүлэх үүрэг хүлээнэ. Ийнхүү техникийн тайлангаа бэлтгэхдээ тухайн тайланг бэлтгэсэн эсхүл хянасан нэг буюу түүнээс дээш мэргэшсэн этгээд нь тухайн объектыг биечлэн шалгах үүрэг хүлээнэ.

NI 43-101 стандартын ерөнхий зарчмын дагуу мэргэшсэн этгээд нь тайлан гаргагчаас хараат бус, харин хараат мэргэшсэн этгээд нь “үйлдвэрлэн гарагч”<sup>65</sup>-ийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрхтэй байна. Мэргэшсэн этгээд нь тайлан гаргагчаасаа “техникийн тайланг бэлтгэн гаргахад мэргэшсэн этгээдийн санал, дүгнэлтэд нөлөөлөх хүчин зүйлс байхгүй гэж үзсэн тохиолдолд” хараат бус байна гэж заасан байна.

### Эрх бүхий этгээдийг олон улсад харилцан хүлээн зөвшөөрөх (Австрали)

2003 онд Австралийн Хөрөнгийн биржээс Хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллагыг тогтоох журмыг баталсан ба ашигт малтмалын нөөцийг тайлагнах эрх бүхий этгээд нь (Австралийн уул уурхай болон металлургийн хүрээлэн эсхүл Австралийн геологийн шинжлэх ухааны хүрээлэнгийн гишүүн бус тохиолдолд/) дараах хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудын гишүүн байна гэж заасан байна. Одоогийн байдлаар тус жагсаалтад:

Хүснэгт 2.

Мэргэжлийн байгууллага	Гишүүнчлэлийн доод хэмжээ
Материал, эрдэс баялаг болон уул уурхайн хүрээлэн Institute of Materials, Minerals and Mining	Гишүүн (MIMMM) эсхүл судлаач (FIMMM)
Лондоны геологийн нийгэмлэг Geological Society of London	Гэрээт геологич (CGeol), гэрээт эрдэмтэн (CSci) эсхүл Европын геологич (EurGeol)
Ирландын геологийн хүрээлэн Institute of Geologists of Ireland	Мэргэшсэн геологич (PGeo)
Европын геологичдын холбоо European Federation of Geologists	Европын геологич (EurGeol)
Америкийн уул уурхай болон металлургийн нийгэмлэг Mining and Metallurgical Society of America	Мэргэшсэн мэргэжилтэн (QP) Qualified Professional
Америкийн мэргэшсэн геологичдын холбоо American Institute of Professional geologists	Мэргэшсэн мэргэжлийн геологич (CPG)

<sup>63</sup>Австрали улсын хувьд эрх бүхий этгээд нь өөрийн хариуцан гаргасан тайлан, үнэлгээндээ захиргааны, иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү: [http://www.jorc.org/docs/liability\\_of\\_cp\\_for\\_JORC\\_reports-livesley.pdf](http://www.jorc.org/docs/liability_of_cp_for_JORC_reports-livesley.pdf)

<sup>64</sup>“technical report” means a report prepared and filed in accordance with this Instrument and Form 43-101F1. Technical Report that includes, in summary form, all material scientific and technical information in respect of the subject property as of the effective date of the technical report; [http://web.cim.org/standards/documents/Block484\\_Doc111.pdf](http://web.cim.org/standards/documents/Block484_Doc111.pdf)

<sup>65</sup>“Үйлдвэрлэн гарагч” /producing issuer/ нь хамгийн сүүлийн санхүүгийн жилд уул уурхайн салбараас 30 сая канад доллараас доошгүй нийт орлоготой, сүүлийн 3 санхүүгийн жилд нийт дүнгээр 90 сая канад доллараас доошгүй орлоготой этгээдийг хэлнэ.

Уул уурхай, металлурги болон хайгуулын нийгэмлэг Society for Mining, Metallurgy & Exploration	SME бүртгэгдсэн гишүүн
Өмнөд Африкийн инженерчлэлийн зөвлөл Engineering Council of South Africa	Мэргэшсэн инженер (Pr Eng)
Өмнөд Африкийн Байгалийн шинжлэх ухааны мэргэжилтний зөвлөл South African Council for Natural Scientific Professions	Мэргэшсэн байгалийн шинжлэх ухааны салбарын мэргэжилтэн (Pr.Sci.Nat.)
Өмнөд Африкийн геологийн нийгэмлэг Geological Society of South Africa	Гишүүн эсхүл судлаач
Өмнөд Африкийн уул уурхай болон металлургийн хүрээлэн The Southern African Institute of Mining and Metallurgy	Гишүүн эсхүл судлаач
Өмнөд Африкийн мэргэжлийн болон техникийн маркшейдерын зөвлөл South African Council for Professional and Technical Surveyors	Уул уурхайн маркшейдер болон мэргэшсэн уул уурхайн маркшейдер
Онтарио мужийн мэргэжлийн инженерүүд Professional Engineers Ontario	Мэргэшсэн инженер (P.Eng)
Бритиш Колумбия мужийн мэргэжлийн инженер болон газарзүйн шинжлэх ухааны салбарын мэргэжилтнүүдийн холбоо Association of Professional Engineers and Geoscientists of British Columbia	Мэргэшсэн геологич (P.Geo), эсхүл Мэргэшсэн инженер (P.Eng)
Манитоба мужийн мэргэжлийн инженер болон газарзүйн шинжлэх ухааны салбарын мэргэжилтнүүдийн холбоо Association of Professional Engineers and Geoscientists of Manitoba	Мэргэшсэн геологич (P.Geo), эсхүл Мэргэшсэн инженер (P.Eng)
Онтарио мужийн мэргэжлийн газарзүйн шинжлэх ухааны салбарын мэргэжилтнүүдийн холбоо Association of Professional Geoscientists of Ontario	Мэргэшсэн геологич (P.Geo)
Ньюфаундленд болон Лабрадор мужийн мэргэжлийн инженер болон газарзүйн шинжлэх ухааны салбарын мэргэжилтнүүдийн холбоо Association of Professional Engineers and Geoscientists of Newfoundland and Labrador	Мэргэшсэн инженер (P.Eng), Мэргэшсэн геологич (P.Geo)
Баруун хойд нутаг дэвсгэрийн мэргэжлийн инженер болон газарзүйн шинжлэх ухааны салбарын P.Eng. мэргэжилтнүүд болон геофизикчдын холбоо Association of Professional Engineers, Geologists and Geophysicists of the Northwest Territories	Мэргэшсэн инженер (P.Eng) эсхүл Мэргэшсэн геофизикч (P.Geoph)
Нова Скотиа мужийн мэргэжлийн газарзүйн шинжлэх ухааны салбарын мэргэжилтнүүдийн холбоо Association of Professional Geoscientists of Nova Scotia	Мэргэшсэн геологич (P.Geo) .
Шинэ Брунсвик мужийн мэргэжлийн инженер болон газарзүйн шинжлэх ухааны салбарын мэргэжилтнүүдийн холбоо Association of Professional Engineers and Geoscientists of New Brunswick	Мэргэшсэн геологич (P.Geo), Мэргэшсэн инженер (P.Eng.)

Альберта мужийн мэргэжлийн инженер, геологич болон геофизикчдын холбоо Association of Professional Engineers, Geologists and Geophysicists of Alberta.	Мэргэшсэн инженер P.Eng., эсхүл Мэргэшсэн геофизикч (P.Geoph)
Саскачеван мужийн мэргэжлийн инженер болон газарзүйн шинжлэх ухааны салбарын мэргэжилтнүүдийн холбоо Association of Professional Engineers and Geoscientists of Saskatchewan	Мэргэшсэн геологич (P.Geo), эсхүл Мэргэшсэн инженер (P.Eng)
Ordre des Geologues du Quйbec <sup>66</sup>	Мэргэшсэн геологич (P.Geo) , гйо.
Ordre des Ingйnieurs du Quйbec <sup>67</sup>	Мэргэшсэн инженер (P.Eng)
Comisiyn Calificadora de Competencias en Recursos y Reservas Mineras (Chilean Mining Commission or Comisiyn Minera) <sup>68</sup>	Бүртгэлтэй гишүүн
Общество экспертов России по недропользованию (ОЭРН) Russian Society of Subsoil Use Experts (OERN) <sup>69</sup>	Эксперт

Хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллага нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

1. Уул уурхай болон /эсхүл хайгуулын салбарын мэргэжилтнүүдийг хамарсан бие даасан зохицуулалт /self-regulatory organisation/ бүхий байгууллага байх;
2. Гишүүдийг гагцхүү мэргэжлийн ур чадвар, туршлагыг нь үндэслэн элсүүлдэг байх;
3. Өөрийн улс орон төдийгүй, дэлхийн аль ч улс оронд байгуулагдсан байгууллагын дагаж мөрдөх мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөхийг шаарддаг байх;
4. Дэлхийн аль ч улс оронд өөрийн мэргэжил болон ёс зүйн стандартын хэм хэмжээг зөрчсөн бол тухайн гишүүнд сахилгын шийтгэл ногдуулах, гишүүнээс түдгэлзүүлэх эрх эдэлдэг байх.

## UNFC-ийн ангилал

НҮБ-ын хатуу ашигт малтмалын нөөц, эрдэс баялгийн ангиллын хүрээ /United Nations Framework Classification for Fossil Energy and Mineral Reserves and Resources (UNFC)/-г 1992 онд НҮБ-ын Европын эдийн засгийн комисс /United Nations Economic Commission for Europe (UNECE)/-оос тогтоосон бөгөөд цар хүрээний хувьд CRIRSCO стандартаас өргөн хүрээг хамрах юм. UNFC нь ашигт малтмал, эрдэс баялгаас гадна газрын тос, байгалийн хий зэрэг бүх төрлийн материалыг багтаадаг, ашигт малтмалын нөөцийг тайлагнахаас гадна ашигт малтмалын ангиллын асуудалд түлхүү чиглэснээрээ онцлог юм.

1999 оноос UNFC болон CRIRSCO нь ижил төрлийн салбарт нэр томьёо, ойлголтыг дүйцүүлэх тал дээр хамтран ажиллаж ирсэн учраас нэр томьёоны хувьд зөрчил тэр болгон гараад байдаггүй, харин UNFC-д заасан нэр томьёог CRIRSCO илүү дэлгэрүүлсэн байдалтай байдаг.

<sup>66</sup>Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү: <http://ogq.qc.ca/en>

<sup>67</sup>Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү: <http://www.oiq.qc.ca/en/aboutOIQ/Pages/default.aspx>

<sup>68</sup>Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү: <http://www.comisionminera.cl>

<sup>69</sup>Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү: <http://www.rosnedra.gov.ru/article/1553.html>

**UNFC-д “мэргэшсэн этгээд”** (qualified person гэх)<sup>70</sup>-ийг “UNFC-д заасан **судалгааны ажил, тайлан** (ТЭЗҮ, геологи-хайгуулын судалгаа, техникийн тайлан г.м.)-г ордын нөөцийн тооцоолол, эрдсийн баялгийн үнэлгээг тухайн материал /ашигт малтмалын төрөл/-ын асуудлаар зохих түвшний туршлагатай, мэргэжлийн зэрэг дэвтэй этгээд хийж гүйцэтгэнэ. Туршлага болон мэргэжилд тавигдах шаардлага нь орон тус бүрт ялгаатай байж болох бөгөөд зарим тохиолдолд тусгай зөвшөөрөл, лиценз шаардаж болно” гэж заасан байна.

UNFC нь тайлагнах стандарт, доод хэм хэмжээг заагаагүй, тайлан үнэлгээг хэрхэн бичиж, боловсруулах удирдамж баталдаггүйгээс гадна олон улсын хөрөнгийн зах зээл дээр хүлээн зөвшөөрөгддөггүй. Өөрөөр хэлбэл UNFC-д тодорхойлогдсон “мэргэшсэн этгээд” нь тайлан, үнэлгээ, тооцоондоо хувийн хариуцлага хүлээхгүй юм.

Дээрх хоёр систем нь утгын хувьд ойролцоо боловч тэдгээрийг харилцан орлуулж хэрэглэж болохгүй. CRIRSCO нь ашигт малтмалын ордын нөөцийн талаар олон нийтэд мэдээлэл өгөх чиг үүрэгтэй бөгөөд бодит тоо хэмжээ, эдийн засгийн тооцоог голлох бөгөөд богино болон дунд хугацааны төлөвлөлт хийхэд тохиромжтой юм. Харин урт хугацааны төлөвлөлт нь UNFC болж хувирах бөгөөд ашигт малтмалын нөөц боломжийн тооцоо үүнд нэмэгдэж орох юм.

\*\*\*

#### АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖ


- <http://www.criusco.com/>
- <http://www.jorc.org/>
- [http://web.cim.org/standards/documents/Block484\\_Doc111.pdf](http://web.cim.org/standards/documents/Block484_Doc111.pdf)
- <http://www.mongolianminingjournal.com/content/14861.shtml>
- <http://www.unece.org/>
- <http://ec.europa.eu>
- [www.mbfh.hu](http://www.mbfh.hu)
- [www.net.jogtar.hu](http://www.net.jogtar.hu)
- [www.complex.hu](http://www.complex.hu)
- <http://uscode.house.gov/browse/prelim@title43/chapter2&edition=prelim>
- USCode, Title 43, Chapter II, 31A <http://www.law.cornell.edu/uscode/text/43/31a>
- Canada Lands Surveys Act. R.S.C., 1985, c. L-6.
- Resolution of the Cabinet of Ministers of the Republic of Uzbekistan “On establishment of the State Committee of the Republic of Uzbekistan on Geology and Mineral Resources” №125, dated May 11, 1991.

<sup>70</sup><http://www.unece.org/fileadmin/DAM/ie/se/pdfs/UNFC/UNFCemr.pdf>

## Хавсралт 1.

**CRIRSCO стандартын хэрэглээ<sup>71</sup>**

- Хуульд эсхүл журамд заасан
- Гаднын эсхүл мужийн хуульд заасан тохиолдолд хүлээн зөвшөөрнө
- Стандартыг хүлээн зөвшөөрөх тухай санамж бичиг байгуулсан
- Урьдчилсан байдлаар CRIRSCO-д элсэх асуудлыг хэлэлцэж байгаа

**Хэрэгцээ, шаардлага**

Олон нийтэд ашигт малтмалын нөөцийн талаар мэдээлэх доод стандартыг тогтоох гол шалтгаан нь олон нийтэд ил тод, нэг загварын, бодитой мэдээлэл хүргэх системийг бий болгосноор хөрөнгө оруулагчдад уул уурхайн салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлж, улмаар улс орны хөрөнгийн зах зээлийн шууд болон шууд бусаар бэхжүүлэх явдал юм. Энэхүү системийн гурван гол зарчим нь: 1/ уул уурхайн төслийн техник болон шинжлэх ухаантай холбоотой мэдээ, мэдээллийг хариуцлагатай болгох “эрх бүхий буюу мэргэшсэн этгээд”-тэй болох. 2/ мэдээ, мэдээллийг техникийн тайланд тусгаж, баталгаажуулах явдлыг “эрх бүхий буюу мэргэшсэн этгээд”-д хариуцуулах. Мөн 3/ ашигт малтмалын ордын нөөц болон ашигт малтмалын баялагтай холбоотой нэр томьёо, ойлголтыг жигдрүүлэх явдал юм.

1. <http://www.casselsbrock.com/files/file/docs/MiningDisclosure.pdf>
2. <http://www.vmine.net/perc/documents/EGM-PAPER-PERC2013.pdf>
3. “1989 онд Дэвид Волш гэгч “Бри-Экс” компанийг байгуулж, Албертийн хөрөнгийн биржид хувьцаагаа гаргажээ. 1995 онд Бусан-II гэх төсөл дээр ажиллаж, ерөмдлөгийн ажил хийснээр үр дүн нь эерэг гарсан байна. Үүний дараа Торонтогийн хөрөнгийн биржид бүртгүүлж нэгж хувьцааг 187.5 доллараар гаргажээ. 1996 оны зургадугаар сард “Бри-Экс” компани Бусан-II орд 39.15 сая унци алтны нөөцтэй гэдгээ тайлагнаж, зургаан сарын дараа 70.95 сая унци болтлоо нөөц нь нэмэгджээ. 1996 оны наймдугаар сард Монреалын хөрөнгийн бирж болон NASDAC-т бүртгүүлжээ. Алтны нөөц нь 70 сая унци болсон гэж мэдэгдсэний дараа “Бри-Экс”-ийг уул уурхайн томоохон компаниуд сонирхож, “Фрипорт-Макморан” компанитай хамтран ажиллах гэрээ байгуулав. Бусан-II ордын нөөц 200 сая унци болон нэмэгдэх боломжтой бөгөөд тэгвэл 95

<sup>71</sup>[http://ec.europa.eu/enterprise/policies/raw-materials/files/docs/eu-us-henley\\_en.pdf](http://ec.europa.eu/enterprise/policies/raw-materials/files/docs/eu-us-henley_en.pdf)

тэрбум долларын өртөгтэй болох талаар компанийн удирдлага мэдээлжээ. Энэ үед “Бри-Экс”-ийн зах зээлийн үнэлгээ 4 тэрбум долларт хүрч байв. Гэрээ хийснээсээ нэг сарын дараа Бусан-II-т хэд хэдэн өрөмдлөг хийсэн “Фрипорт-Макморан”-ынхан маш бага алтны нөөцтэй болохыг тогтоожээ. Ийнхүү хөрөнгийн зах зээлээс хэдэн арван тэрбум доллар босгоод байсан “Бри-Экс” компани хуурамч мэдээлэл өгч, залилан хийж байсан нь тогтоогджээ. Энэхүү алдарт залилангаас үүдэн Канадын Үнэт Цаасны Удирдах газраас NI 43-101 гэх дүрмийг гаргажээ.

<http://www.mongolianminingjournal.com/content/14861.shtml>

4. Жишиг стандартын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү:  
<http://www.criusco.com/template.asp>
5. Гишүүн орнууд болон CRIRSCO стандартын хэрэглээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-с үзнэ үү.
6. Австрали улсын хувьд эрх бүхий этгээд нь өөрийн хариуцан гаргасан тайлан, үнэлгээндээ захиргааны, иргэний болон эрүүгийн хариуцлага хүлээнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү:  
[http://www.jorc.org/docs/liability\\_of\\_cp\\_for\\_JORC\\_reports-livesley.pdf](http://www.jorc.org/docs/liability_of_cp_for_JORC_reports-livesley.pdf)
7. “technical report” means a report prepared and filed in accordance with this Instrument and Form 43-101F1 Technical Report that includes, in summary form, all material scientific and technical information in respect of the subject property as of the effective date of the technical report;  
[http://web.cim.org/standards/documents/Block484\\_Doc111.pdf](http://web.cim.org/standards/documents/Block484_Doc111.pdf)
8. “Үйлдвэрлэн гаргагч” /producing issuer/ нь хамгийн сүүлийн санхүүгийн жилд уул уурхайн салбараас 30 сая канад доллараас доошгүй нийт орлоготой, сүүлийн 3 санхүүгийн жилд нийт дүнгээр 90 сая канад доллараас доошгүй орлоготой этгээдийг хэлнэ.
9. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү: <http://ogq.qc.ca/en>
10. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү:  
<http://www.oiq.qc.ca/en/aboutOIQ/Pages/default.aspx>
11. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү: <http://www.comisionminera.cl>
12. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаас үзнэ үү:  
<http://www.rosnedra.gov.ru/article/1553.html>
13. <http://www.unece.org/fileadmin/DAM/ie/se/pdfs/UNFC/UNFCemr.pdf>
14. [http://ec.europa.eu/enterprise/policies/raw-materials/files/docs/eu-us-henley\\_en.pdf](http://ec.europa.eu/enterprise/policies/raw-materials/files/docs/eu-us-henley_en.pdf)

\*\*\*

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН